



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/75

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14.2.2, 14.2.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны ээлжит бус XII хуралдааны 02, 2016 оны ээлжит бус II хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архитектор төлөвлөлт, скиз зураг, төсөв хийлгэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д үүрэг болгосугай.

2. "50 100" цогцолбор, "Далай ээжийн шүтээн" цогцолбор, "Онгод төв"-ийг байгуулах ажлын архитектор төлөвлөлт, скиз зураг, төсөл боловсруулах ажлын даалгавар гаргах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний үнэ 4500,0 /Дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сан дахь зураг төсвийн зардлаас гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД